



АШУУИС  
Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн захирлын тушаал  
1942

## АНАГААХЫН ШИНЖЛЭХ УХААНЫ ҮНДЭСНИЙ ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 23 өдөр

Дугаар A/146

Улаанбаатар хот

Г Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг  
тооцох журам батлах тухай

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн дүрмийн 1.3, 4.8.1, 4.8.8, 5.6 дахь заалт, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Захиргааны зөвлөлийн 2023 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн №03 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журмыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг 2023-2024 оны хичээлийн жилээс эхлэн мөрдөж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг Багшийн хөгжил, цахим сургалтын газрын дарга (Г.Батбаатар), Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга (Б.Дамдиндорж), Их сургуулийн эмнэлгийн хөгжлийн газрын дарга (Д.Цэрэндагва), Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулалтын газрын дарга (С.Хандмаа), Мэргэжил дээшлүүлэх институтийн захирал (Т.Баясгалан), бүрэлдэхүүн болон салбар сургуулийн захирлууд, эмнэлгийн дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3. Уг тушаал гарсантай холбогдуулан Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн Захирлын үүрэг гүйцэтгэгчийн 2021 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн А/103 дугаартай “Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам”-ыг хүчингүйд тооцсугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга (Б.Зоригбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ

Н.ХҮРЭЛБААТАР



Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн  
Захирлын 2023 оны 06 дугаар сарын 23.-ны  
өдрийн 11:46.. дугаар тушаалын хавсралт

Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн  
Багшийн үйл ажиллагаа, гүйцэтгэлийг тооцох журам

### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэ журмаар Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн (АШҮҮИС) дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам, Багшийн алтан дүрмийн хүрээнд багшийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлнэ.
- 1.2 АШҮҮИС-ийн баглах бүрэлдэхүүн нь үндсэн, гэрээт, зочин багшаас бүрдэх ба Захирлын тушаалаар баталгаажуулна.
- 1.3 АШҮҮИС-ийн тэнхимүүдийг мэргэжлийн онцлог, гүйцэтгэх үүргээр нь ерөнхий эрдмийн, анагаахын суурь боловсролын, эмнэлзүйн тэнхим (Хавсралт.1) гэж ангилна.
- 1.4 Багшийн сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагаагаар гүйцэтгэх ажлыг оноогоор тооцох ба албан тушаалын зэрэглэл харгалзахгүйгээр 1600 оноо байна (долоо хоногийн ажлын 40 цагийг хичээлийн жилийн үргэлжлэх 40 долоо хоногоор үржүүлсэнтэй тэнцэнэ).
- 1.5 Багш нарын эрдэм шинжилгээ, эмнэлзүйн үйл ажиллагааг дэмжих зорилгоор сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааны ачааллын 30 хүртэлх хувийг харилцан шилжүүлэх зохицуулалт хийж болох ба тэнхимийн эрхлэгч баталгаажуулж, бүрэлдэхүүн сургуулийн гүйцэтгэлд нь хяналт тавина.
- 1.6 Төгсөлтийн болон төгсөлтийн дараах сургалтыг доктор болон түүнээс дээш эрдмийн зэрэг, цолтой, мэргэжлийн зэрэгтэй багш удирдана.
- 1.7 Багшийн танхимиын бус сургалтаар гүйцэтгэсэн оноог сургалтын үндсэн ачаалалд тооцохгүй (хээрийн болон зуны дадлага удирдах, оюутны диплом, магистр, докторын ажил удирдах гэх мэт) буюу илүү цагийн үнэлгээгээр үнэлнэ.
- 1.8 Тухайн хичээлийн жилийн багшийн ажлын гүйцэтгэлд тэнхимийн эрхлэгч, бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал хяналт ажиллана.
- 1.9 Багшийн ажлын сургалт, эрдэм шинжилгээ, мэргэжлийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хариуцсан газрууд баталгаажуулж, Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого, зохицуулалтын газар (ТӨСБЗГ) нэгтгэнэ.
- 1.10 АШҮҮИС-ийн тэнхимүүдийн багшийн орон тоог төгсөлтийн өмнөх сургалтын цагийн ачааллаар тооцно.
- 1.11 АШҮҮИС-д оруулсан хөрөнгө оруулалтын дүнгээс хамаарч багшийн сургалтын ачааллыг хөнгөлж болох ба гэрээгээр зохицуулна.

## Хоёр. Багшийн ажлын үнэлгээ

- 2.1. Багшийн хөгжил, цахим сургалтын газар (БХЦСГ) нь багш хөгжүүлэх, албан тушаалын зэрэглэл ахиулах зорилгоор багшийн ажлын үнэлгээг тогтсон хугацаанд тогтмол хийх ба хамрагдах багшийн нэрсийг Захирлын тушаалаар батална.
- 2.2. Дадлагажигч багшийн ажлын гүйцэтгэлийг эхний болон 3 дахь жилд, тэнхимиин багшийн ажлыг 3 жил тутамд, ахлах багш, дэд профессорын ажлыг 4 жил тутамд, профессор багшийн ажлыг 5 жил тутамд дараах жишгээр үнэлнэ (Хүснэгт.1).

**Хүснэгт.1 Багшийн ажлын үнэлгээний оноо**

Албан тушаалын зэрэглэл	Өөрийн үнэлгээний тайлан (50 оноо)			Хөндлөнгийн үнэлгээ (40 оноо)			Гадаад хэлний түвшин (10 оноо)
	Сургалт	ЭШ	MYA	Захирлын үнэлгээ	Тэнхимиин эрхлэгчийн үнэлгээ	Сюутны үнэлгээ	
Профессор	10	20	20	10	20	10	10
Дэд профессор	15	20	15	10	20	10	10
Ахлах багш	18	17	15	10	20	10	10
Багш	20	15	15	10	20	10	10
Дадлагажигч багш	25	15	10	10	20	10	10

- 2.3. 75 түүнээс дээш оноогоор үнэлэгдсэн бол багшийн ажил хангалттай харин 75-аас бага буюу хангалтгүй үнэлүүлсэн тохиолдолд албан тушаалын зэрэглэл бууруулах, хөдөлмөрийн гэрээ цуцлах үндэслэл болно.
- 2.4. Шинээр хөдөлмөрийн гэрээ байгуулсан багш тухайн хичээлийн жилд 10-аас багагүй багц цагийн сургалтад хамрагдах ба БХЦСГ-аас багшлах эрхийн гэрчилгээ олгоно.
- 2.5. Тэнхимиийн саналыг үндэслэн нарийн мэргэшлийн эмч, мэргэжилтэн, судлаачийг гэрээт багшаар ажиллуулах ба бүрэлдэхүүн, салбар сургуулийн захирал гэрээ байгуулж, Захирлын тушаалаар баталгаажуулна.

**Гурав. Багшийн сургалтаар гүйцэтгэсэн ажлыг үнэлэх**

### **3.1 Төгсөлтийн өмнөх сургалтын гүйцэтгэлийг үнэлэх**


- 3.1.1 Төгсөлтийн өмнөх сургалтаар багшийн биелүүлсэн гүйцэтгэлийг Төгсөлтийн өмнөх сургалтын бодлого зохицуулалтын газар баталгаажуулна.
- 3.1.2 Сургалтын хөтөлбөрийн төлөвлөгөөг үндэслэн тэнхимиийн багшийн гүйцэтгэх сургалтын цагийн ачааллыг Боловсрол хариуцсан дэд захирал баталгаажуулна.
- 3.1.3 Тэнхимиийн багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ Хүснэгт.2-т заасан жишгийг баримтална.

**Хүснэгт.2 Тэнхимийн багшийн гүйцэтгэлийг тооцох**

Тэнхим	Сургалт	Хичээл заах Хичээлийн бэлтгэл, явц*	Профессор	Дэд профессор	Ахлах багш	Багш	Дадлага жигч багш
			560	600	640	680	720
Ерөнхий эрдэм	Сургалт	Хичээл заах Хичээлийн бэлтгэл, явц*	280	300	320	340	360
		Эрдэм шинжилгээ Мэргэжлийн үйл ажиллагаа	270+	240+	210+	180+	150+
	Сургалт	Хичээл заах Хичээлийн бэлтгэл, явц*	290+	260+	230+	200+	170+
		Эрдэм шинжилгээ Мэргэжлийн үйл ажиллагаа	320+	290+	260+	230+	200+
Анагаахын суурь боловсрол	Сургалт	Хичээл заах Хичээлийн бэлтгэл, явц*	520	560	600	640	680
		Эрдэм шинжилгээ Мэргэжлийн үйл ажиллагаа	260	280	300	320	340
	Сургалт	Хичээл заах Хичээлийн бэлтгэл, явц*	480	520	560	600	640
		Эрдэм шинжилгээ Мэргэжлийн үйл ажиллагаа	240	260	280	300	320
Эмнэлзүй	Сургалт	Хичээл заах Хичээлийн бэлтгэл, явц*	300+	270+	240+	210+	180+
		Эрдэм шинжилгээ Мэргэжлийн үйл ажиллагаа	380+	350+	320+	290+	260+

\*Хичээлийн бэлтгэл, явцын оноог (хичээлийн хөтөлбөр шинэчлэх, лекц, семинар, дадлагын хичээлд бэлтгэх, сорил, тохиолдол боловсруулах, бие даалтыг үнэлэх гэх мэт) шууд тооцно.

- 3.1.4 Төгсөлтийн өмнөх болон төгсөлтийн сургалтын лекцийн 1 цагт 2 оноо, жижиг бүлгийн хичээлийн 1 цагт 1 оноо, семинарын (хоёроос дээш хэсэг) хичээлийн 1 цагт 1.5 оноогоор тооцно.
- 3.1.5 Тэнхимийн эрхлэгч нь сургалтын илүү цагийг багш нарт жигд хуваарилах ба багш сургалтаар 50 хувь хүртэл илүү оноо гүйцэтгэж болно.
- 3.1.6 Ахлах багш, дэд профессор сургалтаар гүйцэтгэх ачааллын 30 хүртэлх хувийг, профессор 40 хүртэлх хувийг төгсөлтийн дараах сургалтаар гүйцэтгэж болно.
- 3.1.7 Блокийн зохицуулагч нь тухайн блокийн хичээлүүдийг хуваарилах, зохицуулах, хяналт тавих үүрэгтэй бөгөөд ажлын үр дүнг харгалзан сургалтын ачааллаас 80 хүртэл оноог хөнгөлж тооцно.
- 3.1.8 Гэрээт багш нь тухайн хичээлийн жилд 400 оноо хүртэл сургалтын ачаалал гүйцэтгэж болно.
- 3.1.9 Зочин багшийн сургалтаар биелүүлсэн гүйцэтгэлийг албан тушаалын зэрэглэлд үндэслэн тооцно.
- 3.1.10 Тэнхимийн докторант 80, магистрант 40 оноо хүртэл төгсөлтийн өмнөх сургалтын ачааллыг багшийн удирдлагад гүйцэтгэнэ.
- 3.1.11 Зуны дадлага удирдсан багшийн гүйцэтгэлийг ажлын 5 хоногт 1 оюутанд 2 оноо, хээрийн дадлага удирдсан багшийн гүйцэтгэлийг 1 цагт 1.2 оноогоор тооцно.
- 3.1.12 АШУУИС-ийн Захирлын тушаалаар батлагдсан төгсөлтийн шалгалтын мэргэжлийн зөвлөлийн гишүүдийн ажилласан 1 цагийг 1 оноогоор тооцно.
- 3.1.13 Оюутны төгсөлтийн диплом удирдсан ажил тус бүрд 50 оноо, шүүмж бичсэн ажил бүрийг 10 оноогоор тооцно.
- 3.1.14 Салбар, бүрэлдэхүүн сургуулийн захирал нь төгсөлтийн өмнөх, төгсөлтийн сургалтаар 100 онооны ачааллыг заавал гүйцэтгэнэ.



УЛД 0074 5845459

### 3.2 Төгсөлтийн сургалтын гүйцэтгэлийг үнэлэх

- 3.2.1 Төгсөлтийн сургалтаар багшийн биелүүлсэн гүйцэтгэлийг Төгсөлтийн сургалтын бодлого зохицуулалтын газар баталгаажуулж ТӨСБЗГ-т хүрүүлнэ.
- 3.2.2 Төгсөлтийн сургалтыг багшийн сургалтын үндсэн ачаалалд тооцох ба Төгсөлтийн сургалтад хамрагдаж буй суралцагчийн тооноос хамаарч багшийн гүйцэтгэлийг дараах жишгээр тооцно (Хүснэгт.3).

Хүснэгт.3

Төгсөлтийн сургалтын суралцагчийн тоо ба багшийн гүйцэтгэлийн оноо

Суралцагчийн тоо	1 багц цаг	2 багц цаг	3 багц цаг
1	4	8	12
2	6	12	18
3	8	16	24
4	10	20	30
5	12	24	36
6	14	28	42
7	16	32	48
8	20	40	60
9	24	48	72
10-14	28	56	84

- 3.2.3 Магистрын цахим сургалтад гадаадын нэр хүндтэй их сургуулийн зочин профессорын лекцийн 1 цагт 15 оноо, сургалтын төлөвлөгөөнд шинээр тусгагдсан 1 багц цагийн цахим хичээл шинээр бэлтгэж системд оруулсан бол 80 оноо, 2 багц цагийн цахим хичээлийг шинээр бэлтгэж системд оруулах 140 оноо, цахимаар уншсан лекцийн 2 цагт 4 оноо, бие даалтын ажлын үнэлгээ өгсөн суралцагч тутамд 0.2 оноогоор тус тус тооцно.
- 3.2.4 Хамгаалсан докторын ажлын удирдагчид 120, зөвлөхөд 60, танхимиын магистрын удирдагчид 70, зөвлөхөд 20, магистрын цахим сургалтын төслийн удирдагчид 30 оноог тус тус тооцож илүү цагийн үнэлгээгээр олгоно.
- 3.2.5 Хамгаалсан докторын ажлын шүүмжлэгчид 30, магистрын ажлын шүүмжлэгчид 20, цахим сургалтын магистрын ажлын шүүмжлэгчид 10 оноог тус тус тооцож илүү цагийн үнэлгээгээр олгоно.

### 3.3 Төгсөлтийн дараах сургалтын гүйцэтгэлийг үнэлэх

- 3.3.1 Төгсөлтийн дараах сургалтаар багшийн биелүүлсэн гүйцэтгэлийг Мэргэжил дээшлүүлэх институт баталгаажуулж ТӨСБЗГ-т хүргүүлнэ.
- 3.3.2 Эмнэлзүйн тойролт хариуцсан багш долоо хоногт 5 хүртэлх суралцагчийг дадлагажуулах ба гүйцэтгэлийг тэнхимиийн эрхлэгч, координатор багш хянана.
- 3.3.3 Сонгон суралцах хичээлийн нэг багц цагт (25 ба түүнээс дээш суралцагчтай бол) 20 оноо, үндсэн мэргэшлийн сургалтаар 7 хоногт 5 хүртэл суралцагч дадлагажуулсан эсвэл эмнэлзүйн тойролт хариуцсан 46450 бол 1.2 оноо, төрөлжсөн болон мэргэжил дээшлүүлэх сургалтаар 7 хоногт 1 суралцагч дадлагажуулсан бол 1.5 оноо, координатор багшид


суралцагч бүрд 3 оноогоор тооцож тус тус илүү онооны үнэлгээгээр олгоно.

### Дөрөв. Эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийг үнэлэх

- 4.1 Багшийн гүйцэтгэсэн эрдэм шинжилгээний ажлыг Шинжлэх ухаан технологийн газар баталгаажуулж ТӨСБЗГ-т хүргүүлнэ.
- 4.2 Эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэлийн илүү оноог дараагийн 2 жилд шилжүүлэн тооцуулж болох ба харин оноо дутсан тохиолдолд сургалтаар гүйцэтгэсэн илүү оноогоор нөхөн тооцуулна.
- 4.3 Бүрэлдэхүүн сургууль, хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа бол сургалтын ачааллаас 40 оноог хөнгөлж тооцно.
- 4.4 АШУҮИС-иас эрхлэн гаргадаг CAJMS, Эрүүл мэндийн шинжлэх ухаан сэтгүүлийн редакцын зөвлөлийн нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа бол эрхлэн гаргасан дугаар тутамд 20 оноог сургалтын ачааллаас хөнгөлнө.
- 4.5 Докторын зэрэг хамгаалсан бол тухайн хичээлийн жилийн эрдэм шинжилгээний гүйцэтгэлийг шууд тооцох ба эрдэм шинжилгээний гүйцэтгэлийн оноог Хүснэгт.4-ийн жишгээр тооцно.

#### Хүснэгт.4 Эрдэм шинжилгээний гүйцэтгэлийн оноо

#		Үзүүлэлт	Оноо
1	Scopus, Web of Science, PubMed мэдээллийн санд бүртгэлтэй сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	Редакцийн зөвлөлд ажиллах Өгүүлэлд бичсэн шүүмж бүрт Хариуцлагатай зохиогч Нэгдүгээр зохиогч Хамтарсан зохиогч Иш татагдсан тоо бүрт	240 80 480 360 200 12
2	CAJMS сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	Редакцийн зөвлөлд ажиллах Өгүүлэлд бичсэн шүүмж бүрт Хариуцлагатай зохиогч Нэгдүгээр зохиогч Хамтарсан зохиогч	120 80 100 80 60
3	Эрүүл мэндийн шинжлэх ухааны сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	Редакцийн зөвлөлд ажиллах Өгүүлэлд бичсэн шүүмж бүрт Хариуцлагатай зохиогч Нэгдүгээр зохиогч Хамтарсан зохиогч	100 50 90 60 40
4	Хөндлөнгийн шинжээч бүхий ISSN, eISSN кодтой дотоодын эрдэм шинжилгээний сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх	Редакцийн зөвлөлд ажиллах Өгүүлэлд бичсэн шүүмж бүрт Хариуцлагатай зохиогч Нэгдүгээр зохиогч Хамтарсан зохиогч	60 40 72 48 24
5	Төслийн удирдагчаар ажиллах	100 сая төгрөг хүртэл санхүүжилттэй 101-300 сая төгрөг хүртэл санхүүжилттэй 301-ээс дээш сая төгрөгийн санхүүжилттэй	200 260 300
6	Төслийн зохицуулагч, зөвлөхөөр ажиллах	100 сая төгрөг хүртэл санхүүжилттэй 101-300 сая төгрөг хүртэл санхүүжилттэй 301-ээс дээш сая төгрөгийн санхүүжилттэй	100 120 140
7	Төслийн багийн гишүүнээр ажиллах	100 сая төгрөг хүртэл санхүүжилттэй 101-300 сая төгрөг хүртэл санхүүжилттэй 301-ээс дээш сая төгрөгийн санхүүжилттэй	80 90 100
8	Олон улсад оюуны Патент		480



УХ 80745845459


	өмч авах (шинээр авсан жилд)	Бүтээгдэхүүний загвар	240
9	Дотоодод оюуны өмч авах (шинээр авсан жилд)	Шинэ бүтээлийн патент Ашигтай загвар Бүтээгдэхүүний загвар Монгол улсын стандарт Зохиогчийн эрх	240 180 120 200 100
10	Олон улсын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд илтгэл хэвлүүлэх	Уригdsан илтгэл (Нэгдүгээр, хариуцлагатай зохиогч) Аман илтгэл (Нэгдүгээр, хариуцлагатай зохиогч) Ханын илтгэл (Нэгдүгээр, хариуцлагатай зохиогч) Зөвхөн хэвлэгдсэн (Нэгдүгээр, хамтарсан, хариуцлагатай зохиогч)	96 74 60 50
11	Дотоодын эрдэм шинжилгээний хурлын эмхэтгэлд илтгэл хэвлүүлэх	Уригdsан илтгэл (Нэгдүгээр, хариуцлагатай зохиогч) Аман илтгэл (Нэгдүгээр, хариуцлагатай зохиогч) Ханын илтгэл (Нэгдүгээр, хариуцлагатай зохиогч) Зөвхөн хэвлэгдсэн (Нэгдүгээр, хамтарсан, хариуцлагатай зохиогч)	48 30 25 20

Тав. Мэргэжлийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг үнэлэх

- 5.1 Багшийн мэргэжлийн үйл ажиллагааны ажлын гүйцэтгэлийг Их сургуулийн эмнэлгийн хөгжлийн газар баталгаажуулж, ТӨСБЗГ-т хүргүүлнэ.
- 5.2 Эмнэлзүйн тэнхимиийн багш нь АШУҮИС-ийн эмнэлэг болон гэрээт эмнэлэгт долоо хоногт 8-аас доошгүй цаг буюу жилд 320-иос доошгүй цаг эмнэлзүйн ачаалал заавал биелүүлнэ.
- 5.3 АШУҮИС-ийн багш, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулан БХЦСГ, ТӨСБЗГ, ТСБЗГ-тай хамтран зохион байгуулсан сурган, заах арга зүйн сургалтын цагийг багшийн мэргэжлийн үйл ажиллагаанд тооцуулж болно.
- 5.4 Мэргэжлийн үйл ажиллагааны биелүүлээгүй оноог сургалтын оноогоор дүйцүүлэн тооцуулж болох ба тухайн хичээлийн жилд гүйцэтгэсэн мэргэжлийн үйл ажиллагааг Хүснэгт.5-ын жишгээр тооцно.

#### Хүснэгт.5 Мэргэжлийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн оноо

#	Үзүүлэлт	Оноо	
1	АШУҮИС-ийн Хүрээлэн, төв, лаборатори, эмийн сан, эмийн үйлдвэр, гарааны компани, сувилал удирдах	200	
2	Эмнэлзүй, технологийн заавар, удирдамж, эмийн шинжилгээний лабораторийн болон үйлдвэрийн баримт бичиг боловсруулж батлуулах	100	
3	Мэргэжлийн чиглэлээр тэмцээнд оролцох, зохион байгуулах Мэргэжлийн чиглэлээр сургалт зохион байгуулах Олимпиад зохион байгуулах, оюутнуудыг бэлтгэж оролцох Суралцагчдад зориулсан дугуйлан, секц тогтмол ажиллуулах Анги удирдах, чиглүүлэгч багшаар ажиллах, оюутны клуб удирдах Оюутны эрдэм шинжилгээний ажил удирдах Журнал клуб хариуцан зохион байгуулах	50 50 50 100 50 30 30	
4	Олон улсын мэргэжлийн холбооны гишүүнчлэлтэй байх	Удирдах зөвлөлийн дарга, гишүүн Гишүүн	90 70
5	Мэргэжлийн салбар зөвлөлд ажиллах	Дарга, нарийн бичгийн дарга Гишүүн	60 40



УХД007 5845464  
ЧУЙЫНЧЛЭЛ

6	Дотоодын мэргэжлийн холбооны гишүүнчлэлтэй байх	Удирдах зөвлөл, тэргүүн, нарийн бичгийн дарга Гишүүн	50 20
7	Ажлын хэсэгт ажиллаж үр дүнг хүлээлгэн өгсөн байх	АШУҮИС-ийн Захирлын тушаалаар ажлын хэсэгт ажиллах (магадлан итгэмжлэл гэх мэт) АШУҮИС-ийн Бүрэлдэхүүн, салбар сургууль, эмнэлгийн захирлын тушаалаар ажлын хэсэгт ажиллах АШУҮИС-ийн хамтын ажиллагаатай байгууллагад зөвлөх, мэргэжлийн салбар зөвлөлд ажиллах АШУҮИС-ийн бүрэлдэхүүн, салбар сургууль, эмнэлгийн хороонд ажиллах	70 50 50
8	Ном хэвлүүлэх (Хариуцаж бичсэн хэвлэлийн хуудас бүрд)	Сурах бичиг бичиж хэвлүүлэх Сурах бичиг орчуулж хэвлүүлэх Сурах бичиг редакторлах Гарын авлага хэвлүүлэх	8 10 3 3
9	Мэргэжлийн зэрэг ахиулах (зэрэг ахиулсан тухайн жилд)		100
10	Олон нийтэд зориулсан зөвлөгөө, мэдээлэл, ярилцлага, төрөлжсөн мэргэжлийн зөвлөгөө тутамд		10
11	АШУҮИС-ийн хүрээлэн, төв, лаборатори, эмийн сан, эмийн үйлдвэр, тарималжуулалтын талбайд ажиллах цаг тутамд		4
12	Албан ёсоор айлчилж буй гадаадын зочдод орчуулга хийх цаг тутамд болон албан ёсны бичгэн орчуулга хийх 5 хуудас (A4) тутамд		4
13	Профессор, дэд профессор багшийн хичээлд сууж дагалдан суралцах,		4
14	Сурган заах арга зүйн сургалтад хамрагдах (1 багц цаг тутамд)		10
15	Нээлттэй хичээл зохион байгуулах		5
16	АШУҮИС-д оруулсан хөрөнгө оруулалт, мөнгөн орлогын нэг сая төгрөг тутамд (багш нэмэлт урамшуулалт аваагүй тохиолдолд)		40



## АШУУИС-ийн тэнхимийн ангилал

Тэнхим	Бүрэлдэхүүн сургууль
<b>1. Ерөнхий эрдмийн тэнхим</b>	
1. Биөийн тамирын тэнхим	Био-Анагаахын сургууль
2. Гадаад хэлний тэнхим	
3. Ерөнхий эрдмийн тэнхим	Сувилахуйн сургууль
<b>2. Анагаахын суурь боловсролын тэнхим</b>	
4. Анатомийн тэнхим	Био-Анагаахын сургууль
5. Биохимиин тэнхим	
6. Бичил амь судлал, халдвартын сэргийлэлт, хяналтын тэнхим	
7. Гистологийн тэнхим	
8. Дархлаа судлалын тэнхим	
9. Молекул биологи, удам зүйн тэнхим	
10. Физик мэдээлэл зүйн тэнхим	
11. Физиологийн тэнхим	
12. Харилцааны ур чадварын тэнхим	
13. Эм судлалын тэнхим	
14. Эмгэг судлал, шүүх эмнэлгийн тэнхим	
15. Эмгэг физиологийн тэнхим	
16. Анагаахын химийн тэнхим	
17. Биологийн тэнхим	
18. Эмнэлзүйн лабораторийн тэнхим	Анагаах ухааны сургууль
19. Орчны эрүүл мэндийн тэнхим	Нийгмийн эрүүл мэндийн сургууль
20. Урьдчилан сэргийлэх анагаах ухааны тэнхим	
21. Шим тэжээл судлалын тэнхим	
22. Эпидемиологи, биостатистикийн тэнхим	
23. Эрүүл мэндийн бодлогын тэнхим	
24. Эрүүл мэндийн нийгмийн ажил, нийгмийн ухааны тэнхим	
25. Анагаахын суурь шинжлэх ухааны тэнхим	Сувилахуйн сургууль
26. Бие бялдар судлалын тэнхим	
27. Насанд хүрэгчдийн сувилахуйн тэнхим	
28. Нийгмийн эрүүл мэндийн сувилахуйн тэнхим	
29. Суурь сувилахуйн тэнхим	
30. Эх барих, эх хүүхдийн тэнхим	
31. Эм найруулагчийн тэнхим	Эм зүйн сургууль
32. Эмийн технологийн тэнхим	
33. Эмийн хими, ургамал судлалын тэнхим	
34. Эмнэлзүйн эмзүй, менежментийн тэнхим	
35. Эрүүл мэндийн судалгааны тэнхим	Эрдмийн сургууль
36. Анагаах ухааны эрх зүй, боловсрол судлалын тэнхим	
<b>3. Эмнэлзүйн тэнхим</b>	
37. Арьс судлалын тэнхим	Анагаах ухааны сургууль
38. Бөөр судлалын тэнхим	
39. Гэмтэл согог судлалын тэнхим	
40. Дотоод шүүрэл судлалын тэнхим	
41. Зүрх судас судлалын тэнхим	
42. Мэдрэл судлалын тэнхим	
43. Мэс заслын тэнхим	
44. Нүд судлалын тэнхим	
45. Өрхийн анагаах ухааны тэнхим	
46. Радиологийн тэнхим	
47. Ревматологийн тэнхим	
48. Сэргээн засах анагаах ухааны тэнхим	



- 
- 49. Сэтгэцийн эрүүл мэнд судлалын тэнхим
  - 50. Ушги, харшил судлалын тэнхим
  - 51. Хавдар судлалын тэнхим
  - 52. Халдварт өвчин судлалын тэнхим
  - 53. Хоол боловсруулах эрхтэн судлалын тэнхим
  - 54. Хүүхдийн анагаахын тэнхим
  - 55. Цус судлалын тэнхим
  - 56. Чих хамар хоолой судлалын тэнхим
  - 57. Эх барих эмэгтэйчүүдийн тэнхим
  - 58. Яаралтай тусламж, мэдээгүйжүүлэг судлалын тэнхим
  - 59. Нүүр амны гажиг заслын тэнхим
  - 60. Нүүр амны мэс заслын тэнхим
  - 61. Нүүр амны согог заслын тэнхим
  - 62. Нүүр амны технологи, эрүүл ахуйн тэнхим
  - 63. Нүүр амны эмчилгээний тэнхим
  - 64. Хүүхдийн нүүр ам судлал, урьдчилан сэргийлэлтийн тэнхим
  - 65. Шүдний тулгуур эд, сувгийн эмчилгээний тэнхим
  - 66. Дотор өвчин судлалын тэнхим
  - 67. Зүү төөнө, заслын тэнхим
  - 68. Монгол анагаах ухаан судлалын тэнхим
  - 69. Уламжлалт эмчилгээний тэнхим
  - 70. Уламжлалт жор судлалын тэнхим
  - 71. Уламжлалт бария заслын тэнхим
- 

Нүүр ам судлалын  
сургууль

Монгол анагаах ухааны  
олон улсын сургууль



